| | | | | | | байгууллагад шилжүүлсэн газрын төлбөрийн авлагаас 5,1 сая авлага барагдуулж 7.9% биелэлтэй, 3 аж ахуйн нэгжийн 9,4 сая төгрөгийн авлага барагдуулахаар шинээр хуулийн байгууллагуудад шилжүүлж шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байна. Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан 2024 оны гэрээ дүгнэгдэж 29 аж ахуйн нэгжийн гэрээ цуцлагдсан бөгөөд цуцлагдсан аж ахуйн нэгжүүдийн 2025 онд төлөх газрын төлбөрийн дүн 48,5 сая төгрөг байгаа нь оны эцэст төлөвлөгөөт газрын төлбөрийн орлого бүрдэхгүй байх эрсдэл бий болсон тул холбогдох шийдвэр гаргах байгууллагад тайлбар хүргүүлж орлогын төлөвлөгөөнд тодотгол оруулах шаардлага үүсээд байна. | | |
| **Зорилт 2.4 Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилт** | | | | | | | | |
| 2.4.1 | Гадаад, дотоодын ААН, байгууллагуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах. | - | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | - ОХУ-ын Москва хотод болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 26 дугаар хуралдаанд бэлтгэл | 80% | 100/. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ханган оролцсон.<br>1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд "Алтанбулаг" чөлөөт бүсийн хилийн чанад руу чиглэсэн гадаад гарц/орц/ нээх асуудлыг судлан танилцуулах хамтарсан Ажлын хэсгийг байгуулах" тухай Шадар сайдын ажлын алба, Боомтын сэргэлтийн үндэсний хороонд хүсэлт, удирдамжийн төслийг боловсруулан явуулсан.<br>- Монгол, Узбекистаны Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдааны удирдамжид "Алтанбулаг" чөлөөт бүсийн зүгээс саналыг Шадар сайдын ажлын албаруу боловсруулж явуулсан.<br>- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Узбекистаны Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаанд 2025 оны 02 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд оролцсон.<br>- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос хотын Олон улсын худалдааг дэмжих хороогоор | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дамжуулан тус хотын Татварын баталгаат бүсийн удирдлагуудтай цахимаар холбоо тогтоож, албан хүсэлт, хавсралтын хамт илгээн “Алтанбулаг” чөлөөт бүсийн өнөөгийн байдал” хятад хэл дээрх танилцуулга, Чөлөөт бүсийн тухай хуулийг цахимаар хүргүүлж, харилцан айлчлал хийх, “Хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурах тохиролцоонд хүрсэн.<br>– БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Шэнь Минь Зюаньтай хийх уулзалтыг зохион байгуулж Талуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангасан.<br>- БНХАУ-ын Бээжин хотын “BAW” авто машин үйлдвэрлэлийн олон улсын корпорацын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, холбоо тогтоосон.<br>- БНХАУ-ын “Дун Шэн” гэх нүүрсний авто тээвэр, логистикийн компанийн төлөөлөгчдийг чөлөөт бүс дээр хүлээн авч бүсийн нөхцөл байдал, үйл ажиллагааг газар дээр нь танилцуулсан.<br>- БНХАУ-ын Хар мөрөн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мужийн Харбин хотын “Хун гуан” төвлөрсөн дулаан хангамжийн үйлдвэрийн төлөөлөгчдөд бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг газар дээр нь танилцуулсан.<br>-Бүгд найрамдах Туркийн элчин сайдын яамны худалдааны зөвлөх Кадир Жэряантай Туркийн хөрөнгө оруулалтыг татах, үйлдвэр, худалдааг хөгжүүлэхэд хамтран ажиллах, туркийн чөлөөт бүсүүдийн ололт амжилт, туршлагыг авч хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг мэргэшүүлэх зэрэг асуудлуудаас гадна цаашдын техник хамтын ажиллагаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, санал солилцлоо.<br>-БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-гийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч Жу Хэйн Нан болон бусад албаны хүмүүстэй БНСУ-ын чөлөөт бүсүүдийн туршлагыг авч хэрэгжүүлэх, чөлөөт бүсийн албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, Мөн БНСУ-ын зөвлөх, ажилтан нарыг урьж | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллуулах талаар хэлэлцэж сургалтын төлөвлөгөөг монгол хэл дээр орчуулж, төлөвлөгөөг бэлтгэхэд оролцсон. | | |
| 2.4.2 | Төрийн захиргааны байгууллагууд, МҮХАҮТ-тай хамтран ажиллах, гадаад дотоодод зохиогдож буй бизнес-форум, үзэсгэлэн яармагт оролцох ажлыг зохион байгуулах. | | Хурал, зөвлөгөөн, бизнес-форум, үзэсгэлэн яармагт оролцох | 100% | 100% | -Боомтын сэргэлтийн үндэсний хороонд "Алтанбулаг" чөлөөт бүсийн хилийн чанад руу чиглэсэн гадаад гарц/орц/ нээх асуудлын хүрээнд холбогдох бичиг баримт, мэдээлэл бэлтгэн хүргүүлсэн.<br>-Гадаад харилцааны яаманд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Гадаад харилцааны дэд сайд нарын түвшний хуралдаанд "Алтанбулаг" чөлөөт бүсийн гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай мэдээлэл, БНХАУ, ОХУ-тай шийдвэрлэх шаардлагатай асуудал, цаашдын хамтын ажиллагаа хөгжүүлэх санал бэлтгэн явуулсан.<br>- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны удирдлагуудтай чөлөөт бүсийн цахимжуулалтын ажлын нэн тэргүүнд шийдэх асуудлын талаар хэлэлцсэн.<br>-Азийн хөгжлийн банкны төслийн баг, "Astvision" компанийн төлөөллүүдтэй зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Сэлэнгэ аймаг дахь Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн захирагч, Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын дарга, Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч болон холбогдох мэргэжилтнүүдтэй үйл ажиллагаатай холбоотой тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, санал солилцлоо.<br>-Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, хувийн хэвшлийн төлөөлөл болон БНХАУ-ын Хар мөрөн мужийн төр засаг, бизнесийн төлөөллүүдийн хооронд танилцуулга уулзалт 2025.04.11-нд зохион байгуулагдаж, чөлөөт бүсийн онцлог, давуу талыг сурталчлан танилцуулсан. | | |
| 2.4.3 | Арга хэмжээ 3.1. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг таниулах ажлын хүрээг тэлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах, www.altanbulag.gov.mn веб сайтад байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг орос, англи, хятад хэл дээр орчуулан байршуулж олон нийтэд | | www.altanbulag.gov.mn вебсайтын хэвийн үйл ажиллагааг хангаж тогмол ажиллагаатай байх | 100% | 100% | - Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын 12 мэдээ, Фото, видео мэдээллийг, монгол, орос, хятад, англи хэл дээр тухай бүрд хүргэсэн.<br>-www.altanbulag.gov.mn веб сайтад Захирагчийн мэндчилгээ, захирагчийн ажлын албаны утасны жагсаалт, цахим сэтгүүл, бараа эргэлтийн тоон мэдээлэл, тендерийн урилга, | 90% | 100/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цаг тухайд нь хүргэх | | | | | чөлөөт бүс өнөөгийн байдал 2025 мэдээллийг монгол, орос, хятад, англи хэл дээр тус тус шинэчлэн,байршуулсан.<br>-Шинээр томилогдсон алба хаагчдад байгууллагын и-мэйл хаяг шинээр нээж, нууц үг зэргийг сэргээсэн.<br>-https://altanbulag.gov.mn/ Веб сайтын холбоос хэсэгт байгууллагын албан ёсны Фейсбүүк хуудсыг холбох, дахин шинэчлэх талаар Веб хуудсыг хөгжүүлсэн холбогдох байгууллагад санал хүргүүлсэн.<br>-Мөн Шадар сайдын ажлын албаны холбогдох мэдээ мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудас болон веб сайтад байршуулсан.<br>-Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах албатай харилцан мэдээ мэдээллийг солилцож, ЗДТГ-хуудсаар байршуулсан.<br>-Монцамэ агентлагийн Орон нутгийн мэдээ хэсэгт болон Hunnu.mn сайтад "Алтанбулаг" чөлөөт бүсийн үйл ажиллагааг цахимжуулах талаар мэдээллийг байршуулсан.<br>-"Алтанбулаг" чөлөөт бүс | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон ОХУ-ын Бүгд найрамдах НБуриад улстай хамтын ажиллагааны талаарх 2016-2024 оны тойм бэлтгэсэн.<br>- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Гаалийн баталгаат бүс болон Ордос хотын Татварын баталгаат бүстэй тогтмол хамтран ажиллаж байна.<br>-(ТИКА)-ийн Улаанбаатар дахь хөтөлбөрийн зохицуулагч ноён Али Муслутай "Алтанбулаг" чөлөөт бүсийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал болон цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон. | | |
| 2.4.4 | Чөлөөт бүсийн үйл ажиллагааг хөрөнгө оруулагчдад сурталчлах танилцуулга бэлдэх | | Арга хэмжээ тоо | 5 (2024) | 8 (2025) | Татварын баталгаат бүсийн удирдлагууд, -Бээжин хотын "BAW" авто машин үйлдвэрлэлийн олон улсын корпорацын төлөөлөгчид, Баяннуур аймгийн "Дун Шэн" авто тээвэр, логистикийн компанийн төлөөлөгчид, БНХАУ-ын Хар мөрөн мужийн Харбин хотын намын хорооны орлогч дарга, мөн хотын "Хун гуан" төвлөрсөн дулаан хангамжийн үйлдвэрийн зэрэг төлөөлөгчдөд бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг танилцуулан сурталчилж, | 80% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хятад, англи хэл дээрх “Хөрөнгө оруулагчдын гарын авлага”, Чөлөөт бүсийн танилцуулга, “Чөлөөт бүсийн тухай хууль” зэрэг материалыг тараан мэдээ, мэдээллээр хангаж, орчуулга хийн, зохион байгуулж сурталчлан танилцуулсан. | | |
| **Зорилт 2.5 Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилт** | | | | | | | | |
| 2.5.1 | Чөлөөт бүсийн зорчигч тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн мэдээг сар, улирал, жилээр гаргах, чөлөөт бүсэд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүний нэр төрлийн өсөлт , экспорт, импорт, бусад орны чөлөөт бүсийн үйл ажиллагааг судалж зах зээлийн боломж, эрэлт хэрэгцээг тодорхойлсон суурь судалгаатай болох | | статистик тоо мэдээлэл | Тоо (2024) | Тоо (2025) | **Зорчигч ,тээврийн хэрэгсэл:**<br>Нийт зорчигчийн тоо 149993 үүнээс гадаад зорчигч 1403, нийт тээврийн хэрэгсэл 44625 үүнээс гадаад тээврийн хэрэгсэл 126 нэвтэрсэн.<br>**Бараа эргэлт:**<br>Импортын дүн: 6,132.2 сая доллар<br>Борлуулсан барааны дүн: 5,564.5 сая доллар.<br>Бараа эргэлтийн мэдээг Гаалийн ерөнхий газрын статистикийн хэлтэс болон аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч тулган нэгтгэж боловсруулан ажиллаж байна.<br>2025 оны хагас жилийн байдлаар нийт хүнс, гэр ахуй, бараа материал, согтууруулах ундаа, автомашин, бэлэн хувцас, сигар янжуур гэсэн 7 үндсэн төрлөөр бараа бүтээгдэхүүн импортлогдон орж ирж байна. | 80% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Алтанбулаг чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн стратеги төлөвлөгөөнүүд батлагдаж зах зээлийн боломж,эрэлт хэрэгцээг тодорхойлсон суурь судалгаатай болох нөхцөл бий болно. | | |
| 2.5.2 | Байгууллагын урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүгийн жилийн батлагдсан төсвийн тодотгол, төсвийн төсөл, төсөөллийг бодитой аргачлалын дагуу төлөвлөх, хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах гүйцэтгэлийг хянах. | 10,231 сая төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 2025 оны урсгал зардлын батлагдсан төсөвт 429,7 сая төгрөгийн тодотгол<br>2026 оны урсгал зардлын төсвийн төсөлд 4,399.0 сая төгрөг, 2027,2028 оны төсвийн төсөөллийг батлагдсан аргачлалын дагуу боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчид хуулийн хугацаанд хүргүүлсэн, цаашид батлуулах тал дээр анхаарч ажиллана. | 100% | 100% |
| 2.5.3 | Байгууллагын 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэл, “Татварын тухай”, “Төсвийн тухай”, “Төрийн албаны тухай” хууль тогтоомжийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтлөх, хэрэгжилтийг хангуулж, мөрдүүлэх, зарцуулах, | 2,328,1 сая төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар хязгаарлалтай санал дүгнэлт авсан бөгөөд зөрчил арилгах тухай 3 албан шаардлагыг Шадар сайдын ажлын албанаас гаргасан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь биелэлтийг хүргүүлэх , цаашид дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх тал дээр онцгой анхаарч | 80% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж, аудитаар байгууллагаас зөрчилгүй санал дүгнэлт авах. Байгууллагын шилэн дансны мэдээллийг тогтмол хуулийн дагуу хөтөлж ажиллана. | | | | | ажиллана.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар 980,580.6 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 53,617.6 мянган төгрөгийн хэмнэлтэй ажиллаж байна. | | |
| **Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | | |
| 3.1 | Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах энгийн зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн арга хэмжээ авах | | Хэрэгжилтийн хувь | 64 (2024) | 10 (2025) | Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 62 дугаар тушаалын дагуу<br>- Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан 3 ААН,<br>- Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан 2 ААН тусгай зөвшөөрлөө сунгуулах албан хүсэлт ирүүлсний дагуу холбогдох бичиг баримтуудыг үндэслэн согтууруулах ундаа худалдах болон тамхи худалдах тусгай зөвшөөрлийг нь 2 жилийн хугацаатай сунгав.<br>Согтууруулах ундаан худалдах тусгай зөвшөөрлийг нь сунгасан ААН<br>- “Өсөх буудай чөлөөт бүс” ХХК<br>- “Платинум Монгол чөлөөт бүс” ХХК<br>- “Цахим ертөнц чөлөөт бүс” ХХК<br>Тамхи худалдах зөвшөөрлийг нь сунгасан ААН | 100% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "Өсөх буудай чөлөөт бүс" ХХК<br>- "Платинум Монгол чөлөөт бүс" ХХК<br>*<u>Шинээр олгосон тусгай зөвшөөрөл :</u>*<br>Чөлөөт бүсэд шинээр согтууруулах ундаа худалдахаар тусгай зөвшөөрөл олгож өгнө үү гэсэн албан хүсэлт хүсэлт ирүүлсэн 2 ААН-үүдийн холбогдох бичиг баримтуудыг үндэслэн согтууруулах ундаа худалдах зөвшөөрлийг нь 2 жилийн хугацаатайгаар олгов. Үүнд:<br>-"Люксвүүд продуктс чөлөөт бүс" ХХК<br>-"Эгси кеатив бүтик" ХХК<br>Чөлөөт бүсэд шинээр тамхи худалдахаар тусгай зөвшөөрөл олгож өгнө үү гэсэн албан хүсэлт хүсэлт ирүүлсэн 2 ААН-үүдийн холбогдох бичиг баримтуудыг үндэслэн тамхи худалдах зөвшөөрлийг нь 2 жилийн хугацаатайгаар олгов. Үүнд:<br>-Люксвүүд продуктс чөлөөт бүс" ХХК<br>-"Эгси кеатив бүтик" ХХК<br>2025 оны 01 дүгээр сарын 15-16 ны өдрүүдэд чөлөөт бүсэд согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулж байгаа аж | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан.<br>Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулдаг ААН-үүдийн судалгааг тухай бүрд нь захирагч болон Монгол Улсын шадар сайдын ажлын албанд гарган өгч танилцуулан ажиллаж байна. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгосон ААН- 2<br>Тамхи тамхи худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгосон ААН- 2<br>Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан ААН-2<br>Тамхи худалдах зөвшөөрлийн хугацаа сунгасан – 2 | | |
| 3.1.1 | Монгол Улсын Засгийн газарт дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт санал боловсруулж тусгуулна. | - | Саналын тоо | 1 (2023) | 2 (2024) | Монгол Улсын Засгийн газарт дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт санал боловсруулж дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. | 80% | 100% |
| 3.1.2 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина. | - | Гүйцэтгэлийн хувь | 90% | 100% | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Алтанбулаг чөлөөт бүсэд тарих талбайг төлөвлөн | 70% | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэл ажил хангагдаж байна. | | |
| 3.1.3 | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төмвийн санал | | Саналын тоо | 100% | 100% | Алтанбулаг чөлөөт бүсийн 2026 оны Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн төсөөлөлд хөрөнгө оруулалт-2, зураг төсөв ТЭЗҮ-4 буюу нийт 6 санал 16,281.90 тэрбум төгрөгийн санал хүргүүлсэн. | 100% | 100% |
| 3.2 | Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл болон тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг судалж ангилах, үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийг цуцлах | | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Согтууруулах ундаа, тамхины тусгай зөвшөөрөлтэй нийт 36 аж ахуй нэгжээс хуульд заасан хугацаандаа үйл ажиллагаа явуулаагүй, гэрээний заалт зөрчсөн, муу дүгнэгдсэн 4 аж ахуй нэгжийн гэрээг цуцалсан. | 100% | 100% |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР ( АРГА ХЭМЖЭЭ )-ЫН БИЕЛЭЛТ**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайбар/ | Гүйцэтгэлийн хувь | ХШҮ хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2025 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс Төрийн албан хэргийг хос бичгээр явуулна гэж заасны дагуу байгууллагын албан бланкыг хос хэлээр хэвлүүлэх. | Хэрэгжилт, хувь | – | 100% (2025) | Монгол хэлний хуульд 2025 оны 01 үгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн албан хэргийг хос бичгээр хөтөлнө гэж заасны дагуу Архивын ерөнхий газрын эх бэлтгэгч, мэргэжилтэнтэй холбогдож хос бичгээр албан бланкуудын эхийг бэлдүүлж захирагчид танилцуулан зөвшөөрөл авч хос бичгээр албан бланкыг хэвлүүлэн авч 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн албан | 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгцээнд ашиглаж байна. | | |
| 2 | Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн ERP цахим системийн админаар ажиллах | Хэрэгжилт, хувь | – | 100% (2025) | Алтанбулаг чөлөөт бүсийн нийт албан хаагчдад төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP хаяг нээн өгч E-Mongolia академиас сургагч багш нарыг урьж 01 дүгээр сарын 14-ний Улаанбаатар хотод ажиллаж байгаа албан хаагчдад ERP цахим системийн тухай сургалтыг зохион байгуулсан. | 100% | 100% |
| 3 | Захирагчийн ажлын албаны албан хаагчдад хос бичгээр албан хэрэг хөтлөх сургалт зохион байгуулах | Хэрэгжилт, хувь | – | 100% (2025) | 02 дугаар сарын 26-ны өдөр Болорсофт ХХК-иас сургагч багш урьж Захирагчийн ажлын албаны албан хаагчдад хос бичгээр албан хэрэг хөтлөх сургалт зохион байгуулж Захирагчийн ажлын албаны 3 компьютерт кирилл үсгээс монгол бичигт хөрвүүлэг хийх нэг сарын лиценз суулгуулан ажилласан. | 100% | 100% |
| 4 | "Алтанбулаг" Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах зөвшөөрлийг цахим болгох | Хэрэгжилт, хувь | – | 100% (2025) | Цахимжуулалтын ажлын хэсгийн хүрээнд "Алтанбулаг" Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах зөвшөөрлийг цахим болгох талаар E-Mongolia академийн мэргэжилтэн Г.Буднямтай 02 дугаар сарын 01-ний өдрөөс хамтран ажиллаж чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах зөвшөөрлийг 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн цахимаар олгохоор болсон. | 100% | 100% |
| 5 | Онцгой байдлын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө" уулзалт ярилцлагад байгууллагаа төлөөлөн оролцсон | Албан хаагчдын тоо | – | 100% (2025) | Онцгой байдлын ерөнхий газар, Чингэлтэй дүүргийн онцгой байдлын газраас 01 дүгээр сарын 29-ний өдөр "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө" уулзалт ярилцлагад байгууллагаа төлөөлөн оролцож Засгийн газрын 11 дүгээр байранд байрлах бүх албан байгууллагуудын хамтаар 01 дүгээр сарын 31-ний өдөр "Гамшгаас хамгаалах тактик" сургалтад алба хаагчид 100% хамрагдсан. | 100% | 100% |
| 6 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивын баримт материалыг 2004-2025 оны шинэчлэн цэгцэлж | Хэрэгжилт, хувь | – | 100% (2025) | Архивын ерөнхий газрын мэргэжил, арга зүй, удирдлагын газрын холбогдох албан тушаалтнуудтай холбогдож мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх мэргэжилтэн урин авчирч хөтлөх хэргийн нэрийн жагсаалт архив, албан хэрэг хөтлөлтийн талаар заавар | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Улсын архивд хүлээлгэн өгөхөөр материалыг цэгцлэх | | | | зөвлөгөө аван ажиллаж байна. | | |
| 7 | Удирдлагаас өгсөн шуурхай үүрэг даалгавар | Цахим системд тайлагнасан төсөл, арга хэмжээ, төсөвт өртөг 200.000,000 сая.төгрөг | - | 100% (2025) | Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 44 дугаар тушаал, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 27 дугаар тушаал хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.<br>Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Алтанбулаг чөлөөт бүсийн нэвтрэх хэсэгт "Ухаалаг гарц" байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд Захирагчийн А/53 захирамжийн хүрээнд 5 гишүүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулагдан амжилтай зохион байгуулж ажилласан. | 100 % | 100% |
| 8 | Шуурхай үүрэг даалгаварын биелэлт | Үүрэг даалгавар цаг хугацаанд биелүүлэх. | 100% (2024) | 100% (2025) | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний ажилтай холбоотой ажлын хэсгийн хүрээнд архивт хадгалагдаж буй дэд бүтэцтэй холбоотой 17 нэр төрлийн 82ш боть материалтай нэг бүрчлэн танилцаж мэдээллийн хүснэгт бэлтгэсэн.<br>Алтанбулаг чөлөөт бүсэд гаалийн теле хяналтын женетик нэвтрүүлэх ажлын хэсгийн хүрээнд Юнившн компаниар 2км орчим шилэн кабелийн сүлжээг татуулж нийт 37 аж ахуй нэгжийг шилэн кабелийн сүлжээнд холбосон. Өнө тех ХХК-р хяналтын нэгдсэн серверийг байгуулсан.<br>"Алтанбулаг" чөлөөт бүсийн дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн өвөлжилтийн бэлтгэл | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | | |
| 9 | Шуурхай үүрэг даалгаварын биелэлт | Үүрэг даалгавар цаг хугацаанд биелүүлэх. | 100% (2024) | 100% (2025) | БНСУ-ын (КОЙКА)-ийн Монгол Улс дахь Төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч Жу Хэйн Нан болон сургалт хариуцсан ажилтан Д. Түвшинсайхан нартай хамтран ажиллах талаар “Алтанбулаг” чөлөөт бүсийн төлөөлөл санал солилцлоо.<br>Тус уулзалтаар:<br>1. Хоёр орны хамтын ажиллагааны хүрээнд хүний нөөцийг чадавхжуулах талаар сургалтад хамруулах.<br>2. “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийг эрчимжүүлэх ажлын хүрээнд БНСУ-ын туршлагатай зөвлөх мэргэжилтэн урьж ажиллуулах талаар хэлэлцсэн. | 100% | 100% |
| 10 | Шуурхай үүрэг даалгаварын биелэлт | Үүрэг даалгавар цаг хугацаанд биелүүлэх. | 100% (2024) | 100% (2025) | - Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар нийслэл, дүүрэг, аймаг, сумуудын барилга байгууламжид нэгдсэн үзлэг шалгалт хийгдэх ажлын дагуу 2025 оны 1 сарын 27,28-ны өдрүүдэд “Алтанбулаг” чөлөөт бүс дээр ажиллах болсныг хөрөнгө оруулагч ААН-д мэдээлж, Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газрын гал түймрийн Улсын хяналтын байцаагч, дэслэгч М.Мөнх-Эрдэнээс хяналтын хуудсыг авч зар мэдээлэл хүргүүлсэн.<br>-“Люүсвүүд продуктс чөлөөт бүс” ХХК нь барилга байгууламжаа улсын комисст хүлээлгэн өгөхөд гишүүнээр орж ажилласан.<br>- Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар нийслэл, дүүрэг, аймаг, сумуудын барилга байгууламжид нэгдсэн үзлэг шалгалт хийгдэх ажлын дагуу 2025 оны 1 сарын 27, 28-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн онцгой байдлын газрын Гал түймрийн Улсын хяналтын байцаагч, дэслэгч М.Мөнх-Эрдэнэ “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч ААН-ийн барилга байгууламжид үзлэг ,шалгалт хийж бичгээр албан шаардлага хүргүүлж, хүргүүлсэн албан шаардлагын хугацаа энэ сарын 21-ний өдрөөр дуусаж байгаа бөгөөд 2 ААН бичгээр хариу ирүүлсэн. | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Шаардлагатай тохиолдолд Улаанбаатар хотод болон орон нутагт ажиллаж байгаа ажилтнууд хот болон орон нутагт томилолтоор ажиллах; | Үүрэг даалгавар цаг хугацаанд биелүүлэх. | 100% (2024) | 100% (2025) | - Монгол улсын Шадар Сайдын Ажлын албанаас Чөлөөт бүсийн удирдлагуудад өгсөн чиглэлийн дагуу "Алтанбулаг" чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах аж ахуй нэгжүүдийн гэрээ дүгнэх, тэдгээрийн газар ашиглалт, тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарж буй зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх хяналт тавихаар чөлөөт бүс дээр ажилласан.<br>- "Алтанбулаг" чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны төлөөллүүд Сэлэнгэ аймгийн засаг дарга, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтын удирдлагуудтай Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн удирдлагуудтай уулзалт хийх, Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг хөрөнгө оруулагчидтай цаг үеийн байдал болон цаашдын үйл ажиллагааны талаар хэлэлцсэн.<br>- "Алтанбулаг" чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны төлөөллүүд Сэлэнгэ аймгийн засаг дарга, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн удирдлагуудтай чөлөөт бүс дээр гарж буй зөрчлийг арилгах, шийдлийн талаар уулзалдсан.<br>- Алтанбулаг Чөлөөт бүс, Алтанбулаг хилийн боомт дээр "Хилээр нэвтрэх хүсэлт" үйлчилгээг E-Mongolia-р дамжуулан авах ажлын хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсэд ажиллалаа.<br>- Алтанбулаг" чөлөөт бүсийн дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны 2025 онд техникийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх төлөвлөгөөний дагуу бүсийн доторх бохир усны шугам сүлжээнд үзлэг шалгалт хийхээр чөлөөт бүс дээр ажиллав.<br>- БНХАУ-ийн цахилгаан эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг Тайяка үйлдвэрт очиж (Алтанбулаг чөлөөт бүсийн 35/10 кВ-ийн өргөтгөлийн ажлын хүрээнд хийгдэж буй Сүхбаатар 110/35/10 кВ-ын трансформатор) үйлдвэрлэх явцыг газар дээр нь | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | очиж танилцсан. | | |
| **Хэрэгжилтийн ерөнхий дүн (5 зорилтын хүрээнд 42 арга хэмжээтэй)** | | | | | **- Нийт 42 ажил төлөвлөсний 26 ажил нь 100% биелэлттэй, 1 ажил нь 90% биелэлттэй, 8 ажил нь 80% биелэлттэй, 3 ажил нь 70% биелэлттэй, 1 ажил нь 60% биелэлттэй, 3 ажил нь 50% биелэлттэй байна.** | **86.28%** | 82,11% |

**ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Гүйцэтгэлийн хувь | ХШҮ хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1.1.Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрт хамрагдах, холбогдох дүрэм журмыг судлах. | -Сургалт семинарт хамрагдснаар төрийн албан хаагчийн ёс зүй мэдлэг боловсрол дээшилсэн байх | 10 (2024) | 15 (2025) | Байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулсан.<br>1. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч;<br>2. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч;<br>3. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч;<br>4. Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч;<br>5. АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс боловсруулсан мэдүүлэг гаргагчдад зориулсан онлайн сургалтад 9 албан хаагч;<br>6. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем erp.e-mongolia.mn сургалтад 25 албан хаагч;<br>7. “Гамшгаас хамгаалах тактик”-ийн сургалтад 21 албан хаагч;<br>8. Болорсофт ХХК-аас “Монгол бичгээр албан хэрэг хөтлөх” сургалтад 18 албан хаагч;<br>9. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтад 3 албан хаагч;<br>10. Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 18 албан хаагч тус тус хамрагдсан. | | |